



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2006 оны 9 сарын 6 өдөр

Дугаар 195

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчит газар байгуулах  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2006 оны 1/1787 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Нийслэлийн Орон сууц нийтийн аж ахуйн газрын харьяа Баянгол дүүргийн "Өгөөмөр", "Батбаян", Сонгинохайрхан дүүргийн "Баянхошуу-Ус" салбарыг 2006 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс нийслэлийн өмчит газар болгон өөрчлөн байгуулсугай.

Хоёр. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Ц.Батбаяр/-т ДААЛГАХ нь:

1. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг шинэчлэн баталж, удирдлагыг томилон, эд хөрөнгийг хүлээлгэн өгөх;

2. Нийслэлийн өмчит газруудын хэвийн үйл ажиллагаа, 2006-2007 оны өвөлжилтийн бэлтгэл ажилд хяналт тавьж, тогтоолын хэрэгжилтийг 2006 оны 10 дугаар сарын 1-ний дотор Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулах.



ДАРГА  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ  
ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД:

*Баярмаа* Н.БОЛОРМАА  
*Д.Баасансүрэн* Д.БААСАНСҮРЭН  
*Ш.Алтангэрэл* Ш.АЛТАНГЭРЭЛ  
*Я.Аюушжав* Я.АЮУШЖАВ  
*С.Баярмөнх* С.БАЯРМӨНХ  
*Т.Билэгт* Т.БИЛЭГТ  
*Г.Мөнхбаяр* Г.МӨНХБАЯР  
*С.Отгонбат* С.ӨТГОНБАТ  
*Б.Ундармаа* Б.УНДАРМАА

My.Doc.Togtool2

0101148